



ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/4/2

Зуунмод

Г Мал, тэжээвэр амьтдын тооллогын ажлыг
зохион байгуулах тухай Г

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-ийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дах заалт, “Статистикийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Засгийн газрын 2003 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 224 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зуунмод сумын хэмжээнд 2023 оны мал, тэжээвэр амьтдын тооллогыг аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 01/2075 тоот албан бичгийн дагуу Мал, тэжээвэр амьтдын тооллогыг 12 дугаар сарын 07–17-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Мал, тэжээвэр амьтдын тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

-Засаг даргын орлогч

Гишүүд:

-Засаг даргын Тамгын газрын дарга

-Санхүүгийн албаны дарга

-ХАА-н тасгийн дарга, мэргэжилтэнүүд

-Хууль эрх зүйн мэргэжилтэн

-Захирагчийн албаны мэргэжилтэн

-МЭ-ийн тасгийн тархвар зүйч

-Олон нийт интернэт мэдээллийн ажилтан

-ЗДТГ-ын жолооч

-ЗДТГ-ын нярав

-“Н бэлэг” ХХК-ны малын эмч

-Өрхийн эмч нар

-Багийн Засаг дарга, зохион байгуулагч,

хэсгийн ахлагч нар

Нарийн бичгийн дарга:

-Төрийн сангийн мэргэжилтэн

3.Мал, тэжээвэр амьтдын тооллогын шаардагдах төсвийг 1 дүгээр хавсралтаар, ажлын хэсгийн хуваарь маршрутыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Мал тооллогын ажлыг зохион байгуулахад шаардагдах 500 000 /Таван зуун мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц сангаас, 647200 /Зургаан зуун дөчин долоон мянга хоёр зуун/ төгрөгийг Засаг даргын Тамгын газрын бусад холбогдох зардлаас, нийт 1 147 200 /Нэг сая нэг зуун дөчин долоон мянга хоёр зуун/ төгрөгийг тус тус гаргахыг сумын ЗДТГ-ын дарга (Г.Батжаргал), Нягтлан бодогч (Ц.Мөнхтуяа) нарт зөвшөөрсүгэй.

5.Мал, тэжээвэр амьтдын тооллогын ажлын хэсгийн дарга, нарийн бичиг, гишүүдэд ДААЛГАХ нь:

5.1.“Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн 2023 оны тооллого, маягт МТ1”, “Шинээр гаргасан, засварласан худгийн тайлан, маягт № ба”, “Малжуулалтын талаар авсан арга хэмжээний тайлан, маягт №9” маягтуудыг зааврын дагуу зөв бөглөж, тоолж буй мал, тэжээвэр амьтдыг нүдээр үзэж, биечлэн тоолох

5.2.Мал тооллогын веб-д суурилсан программ хангамжийг ашиглан өрх, аж ахуй нэгж, байгууллагаар шивэлтийг хийж, тооллогын “МТ-1” маягтын бүх үзүүлэлтээр сумын түвшинд нэгтгэл гаргах.

5.3.Мал тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийхэн цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал үүсэж нийт нутгаар цасан бүрхүүл тогтсон байгаа энэ үед эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжлийн байгууллагаас өгч буй заавар зөвлөмжийг малчдад хүргүүлж ажиллах.

6.Сумын ИТХ-ын 2021 оны 04 дүгээр тогтоолоор “Малын тоо толгойн албан татвар”р, галт зэвсгийн тооллого татвар хураамжийг эрчимжүүлж ажиллахыг мал тооллогын ажлын хэсэгт даалгасугай.

7.Мал, тэжээвэр амьтдын тооллогын ажлыг хуулийн хугацаанд нь чанартай зохион байгуулж холбогдох мэдээ, тайланг гаргаж хүргүүлэхийг ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ч.САРАНГЭРЭЛ

Сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 1112 дугаар захирамжийн I дүгээр хавсралт

2023 ОНЫ МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТООЛЛОГО ЯВУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Машин	Явах /км/	Тоо хэмжээ /л/	А-92 /Нэг бүрийн үнэ/ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/	Тайлбар
1	Шатахуун	1-р хэсэг: /100 км-20л/	750	150	2390	358500	Сумаас зүүн чиглэлд малчин өрхүүдээр явж мал тоолох, өвөлжилтийн бэлтгэл ажил, малын хөлийн татвар бүрдүүлэхэд анхаарч хяналт тавьж ажиллах.
		2-р хэсэг: 00-03 ТӨВ Прадо А-92 /100 км-20 л/	850	170	2390	406300	Сумаас баруун чиглэлд малчин өрхүүдээр явж мал тоолох, өвөлжилтийн бэлтгэл ажил, малын хөлийн татвар бүрдүүлэхэд анхаарч хяналт тавьж ажиллах.
		Хяналт: 00-03 ТӨВ Парадо А-92 /100 км-20 л/	500	100	2390	239000	Хөдөө малчин өрхөөр явж хяналтын тооллого хийх.
		Багуудад /50 км-10л/	300	60	2390	143400	Багийн төвийн 6-н багт мал тоолох ажиллагаанд зориулж баг тус бүрт 10 л шатахуун өгөх.
	Дүн		2400	480	2390	1147200	

ТӨСӨВ ХИЙСЭН:
ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН ДАРГА

Б.БАТЖАРГАЛ

Мал тооллогын ажлыг зохион байгуулах
нээлтийн ажлын хөтөлбөр

2023.12.04

Зуунмод

№	Хөтөлбөрийн дараалал	Хугацаа	Хариуцах эзэн
1	Мал тооллогын ажлын хэсгийг бүртгэх	7:50 – 8:00	Төрийн сангийн мэргэжилтэн Р.Батцэцэг
2	Мал тооллогын ажлыг нээж үг хэлэх	8:00 – 8:10	Засаг дарга Ч.Сарангэрэл
3	Төрийн дуулал эгшиглүүлэх	8:10 - 8:15	ОНИМТ-ийн ажилтан Г.Уянга
4	Мал тооллогын ажилд амжилт хүсэж мэндчилгээ дэвшүүлэх	8:15 – 8:20	ИТХ-ын дарга Г.Мөнхбадрал
5	Мал тооллоготой холбогдуулан үүрэг чиглэл өгөх.	8:20 – 8:30	ЗДТГ-ын дарга Г.Батжаргал
6	Ажлын хэсгийхэнд амжилт хүсч урлагийн мэндчилгээ. /морин хуур, ая дууны мэндчилгээ/	8:30 – 8:40	Соёлын төвийн эрхлэгч Ш.Батмөнх
7	Үдэлт	8:40 – 9:00	Ажлын хэсэг

Ажлын хэсэг



Сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн Ажлын хэсгийн захиралын 2 дугаар хавсралт

2023 ОНЫ МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТООЛЛОГО ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН ХУВААРЬ, ЯВАХ МАРШРУТ

№	Ажлын хэсэг	Явах чиглэл	Тооллого хийх газрын нэр	Автомашин	Туулах зай	Хамрах	Гүйцэтгэх ажил
1	Ч. Одончимэг-4-р багийн Засаг дарга Б.Отгонбаяр-6-р багийн Засаг дарга Б.Туул-1-р багийн Засаг дарга н.Оюун-Эрдэнэ /хүний эмч/ Э.Долгормаа-Тархвар зүйч П.Баг-Аюуш /жолооч/	Зүүн талын хэсэг	Сэргэлэн, 4-р зөрлөг, Майдар сити, Зүүндэлгэрийн ам, Өгөөмөрийн ам Өвар шаварт, Ар шаварт, Салхин сэнс, Манзуширын ам, Баруун-Зуунмодны ам, Бугын САА, 61-р зөрлөг, Номтын ам, Буга үржүүлгийн ам, Долоогийн шороо	70-43 ТӨВ Делика-А-92 /1км-20 л/	750 км	Зуунмод сумын малчин болон мал бүхий өрх	Мал тэжээвэр амьтдыг нүдээр үзэж бичлэн тоолох, ХАӨМСан дахь өрхийн дэвтрийн тулгалт хийх, малчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулах, өвөлжилтийн байдлыг үнэлэх. Малын тоо толгойн албан татварыг бүрдүүлэх
2	Ш.Цэндсүрэн-3-р багийн Засаг дарга Р.Баярсайхан-5-р багийн Засаг дарга Б.Сансар /Малын эмч/ Н.Дашэвэгэ- ХАА-н тасаг Ц. Мөнхтуяа /хүний эмч/ Б.Эрдэнэбат /жолооч /	Баруун талын хэсэг	Сэргэлэн, Баян-Өнжүүл, Алтанбулаг, Номтын ам, Баянхан хөндлөн, Тахилт, Хүрэн дэл, Гурван түрүү, Цагаан дэрс, Гүн бүрд, Ногоон дов, Тэмээнчулуут, Сэвсүүл, Долоон уул, Антенны энгэр, Өндөр довны жуулчны бааз, Замын булаг	00-03 ТӨВ Прадо А-92 /1км-20 л/	850 км		
3	Г.Мөнхбадрал-Сумын ИТХ-ын дарга Ч.Сарангэрэл-Сумын Засаг дарга Н.Энхсайхан -Засаг даргын орлогч Г.Батжаргал-ЗДТГ-ын дарга Б.Батжаргал-ХАА-н тасгийн дарга Н.Цанлигсүрэн-Санхүү албаны дарга	Хяналтын тооллого	Номтын ам, Манзуширын ам, Баруун-Зуунмодны ам, Зүүндэлгэрийн ам, Шавартын ам, Өгөөмөрийн ам, Сэргэлэн сум, Ногоон дов, сумын төв дотор	00-03 ТӨВ Прадо А-92 /1км-20 л/	500 км		Хяналтын тооллого

4	Д.Өнөрбаяр - ХАА-н тасаг Р.Батцэцэг-Төрийн сан мэргэжилтэн Багийн Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нар	Төвд тооллого хийх	Зуунмод сумын төвд Номт, Ланс, Баянхошуу, Зүүндэлгэр, Нацагдорж, Баруунзуунмод багийн төвд байгаа малчин, мал бүхий өрхүүдэд	300 км	Мал тэжээвэр амьтдыг нүдээр үзэж бичлэн тоолох, ХАӨМСан дахь өрхийн дэвтрийн тулгалт хийх, малчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулах, өвөлжилтийн байдлыг үнэлэх
5	Н.Энхсайхан- Засаг даргын орлогч Р.Батцэцэг-Төрийн санийн мэргэжилтэн Б.Батжаргал-ХАА-н тасгийн дарга Н.Дашзэвгэ-ХАА-н тасаг Багийн Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нар ДҮН	Нэгтгэл хийх		-	Ажлын хэсгээс тооллогын материалыг авч, дунг нэгтгэн гаргаж, хүргүүлэх
				2400 км	

ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР.